Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Лүндээжанцан -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

С.Баярцогт -Улсын Их Хурлын гишүүн
З.Баянсэлэнгэ -Улсын Их Хурлын гишүүн
Р.Бурмаа -Улсын Их Хурлын гишүүн
Д.Оюунхорол -Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Баярцэцэг -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга


Т.Бат-Өлзий -Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга

Н.Баярмаа -Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн

Ч.Ариунхур -Хууль зүйн байнгын хорооны зөвлөх

Ч.Батбямба -Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагалдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Батзандан - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Д.Батцогт - Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат - Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Баярцэцэг - Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Т.Бат-Өлзий - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга

Г.Эрдэнэбаяр - Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал

Ц.Хүрэлбаатар	-Тагнуулын ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга
О.Батбилэг	-Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн хэлтсийн дарга
Б.Төмөрбат	-Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга
Т.Ганбаатар	-Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн
П.Болд	-Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөн байцаагч
Б.Батхишиг	-Тагнуулын ерөнхий газрын Үндэсний тагнуулын академийн тэнхимийн эрхлэгч
Ж.Төгс-Очир Л.Нямдаваа	-Тагнуулын ерөнхий газрын ажилтан -Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Э.Түвшинжаргал Ч.Ариунхур Ч.Батбямба	-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх -Хууль зүйн байнгын хорооны зөвлөх -Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 5 сарын 22 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл”-ийг хэлэлцээд үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны тогтоолын төсөл бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ганбат - Улсын Их Хурлын гишүүн


Гишүүд:

Ж.Батзандан - Улсын Их Хурлын гишүүн
Р.Бурмаа - Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Бямбадорж - Хүний эрхийн үндэсний комиссын дарга
П.Оюунчимэг - Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн
Г.Золжаргал - Хүний эрхийн үндэсний комиссын ажлын албаны дарга
Э.Түвшинжаргал - Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх
Ч.Батбямба - Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолын 2 дахь заалтад заасан Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд Хадгаламж, зээлийн хоршооны хохирогчдын нэгдсэн түр хорооны дарга Я.Батхүү, “Глоб кредит хадгаламж, зээлийн хоршооны хохирол барагдуулах хамтын Бат итгэл нийгэмлэг” төрийн бус байгууллагын тэргүүн С.Дорждулам нарыг нэмсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 13.

Улаанбаатар хот

“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо 12 дахь удаагийн “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” /цаашид “Комиссын илтгэл” гэх/-ийг 2013 оны 4 дүгээр сарын 24, 5 дугаар сарын 22-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцэж, илтгэлтэй холбогдуулан 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

Комиссын илтгэлийг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын хийсэн хяналт шалгалт, судалгаа, комиссын гишүүний шаардлага зөвлөмж, байгууллагуудаас ирүүлсэн арга хэмжээний тайлан, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан мэдээлэл, иргэдээс гаргасан гомдлыг үндэслэн боловсруулж, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргуулахаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн санал, Комиссын илтгэлд дурдсан санал, зөвлөмжийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Комиссын илтгэлд дэвшүүлсэн санал, зөвлөмжийг сайшаасугай.

2. Комиссын илтгэлтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1/Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх өмнөх илтгэлүүдэд дурдагдсан биелэгдээгүй байгаа санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангах арга хэмжээ авах;

2/Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод, Хүний эрхийн зөвлөл, тусгай илтгэгч, ажлын хэсгээс Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хагас жил тутам хэлэлцэж, холбогдох байгууллагуудад тайлагнаж байх;

3/уурхайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийгээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог

чангатгах, ашигт малтмал олборлох нөхөн сэргээлтийн үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих боломжийг олгох;

4/нүүрс, төмрийн хүдэр зэрэг овор ихтэй ашигт малтмал ашиглах бол тухайн орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор төмөр зам, эсхүл хатуу хучилттай замыг байгуулсны дараа олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл олгох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, мөн уул уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой автомашины болон замын даац, ашиглалтын талаарх бодлого, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн батлах;

5/уул уурхайн салбарт ажиллагсдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Уул уурхайн үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 176 дугаар конвенцид нэгдэн орох, уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүний амь нас хохирсон, бие эрхтэнд гэмтэл учирсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

6/“Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангах тухай” Аархусын конвенцид нэгдэж орох, ашигт малтмал хайх, олборлох, байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд аймаг, сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн бодит оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

7/Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн гуравдугаар нэмэлт протоколд нэгдэн орох;

8/хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, хүүхдийг үл хайхрах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх хууль тогтоомжийг шинэчилж сайжруулах, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” (MNS 6264-2011) стандартыг хангаж ажиллах;

9/бүх нийтийн ерөнхий боловсрол, суурь боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлсэн шашны тусгай сургалттай сургуулийг үндэсний хэмжээнд бүсчлэн байгуулах;

10/тусгай сургуулийн барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сургуулийн онцлогт тохируулах, цэцэрлэг, дотуур байр бүхий ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс бүрдсэн цогцолборуудыг улсын хэмжээнд байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх, боловсрол, нийгэм, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангуулах чиглэлээр бодитой, үр дүнтэй арга хэмжээ авах;

11/Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн

лесбиян, гей, бисексуал, трансгендер хүмүүсийн хүний эрхийн талаарх хамаарах зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;


12/энэ тогтоолд заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2013 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

13/Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын аймаг бүрд ажиллах орон тооны 21 ажилтны цалин, шуудан холбоонд шаардагдах зардлыг Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулж, санхүүжүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ш.Түвдэндорж/-нд даалгасугай.

4.Комиссын илтгэлд дэвшүүлсэн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг жил бүр тооцож, санал зөвлөмжийг хэрэгжүүлээгүй холбогдох байгууллага, албан тушаалтны талаар Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хамт Улсын Их Хуралд тусгайлан танилцуулж байхыг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын дарга /Ж.Бямбадорж/-д даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Ажлын дэд хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын даргын 2013 оны 115 дугаар захирамж, тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Мөрдөх албаны тухай хуулийн төсөл болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын даргын 2013 оны 115 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын дэд хэсгийн ахлагч:

Д.Батцогт

Улсын Их Хурлын гишүүн

Ажлын дэд хэсгийн гишүүд:

Г.Эрдэнэбат

Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх

Ж.Баярцэцэг

Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга

Т.Бат-Өлзий

Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга

Б.Баасандорж

Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга

Э.Амарбат

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах албаны дарга

М.Бамбадорж

Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны тасгийн дарга

Ц.Хүрэлбаатар

Тагнуулын ерөнхий газрын Төрийн захиргаа удирдлагын газрын орлогч дарга, Хуулийн хэлтсийн дарга

Ц.Баярсайхан

Тагнуулын ерөнхий газрын Сөрөг тагнуулын газрын орлогч дарга

Ж.Ганбаатар

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга

Ц.Батсүх

Цагдаагийн ерөнхий газрын Улсын мөрдөн байцаах газрын дарга

Ц.Азбаяр

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга

Д.Эрдэнэбаатар

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга

Б.Батаа

Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах референт

Б.Болор-Од

Ц.Гантулга

Т.Оюунчимэг


Э.Түвшинжаргал

Г.Нямдэлгэр

Ч.Батбямба

Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн
бодлогын газрын мэргэжилтэн
Шүүхийн шинжилгээний үндэсний
хүрээлэнгийн дэд захирал
Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн
сургуулийн Эрүүгийн байцаан шийтгэх эрх
зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор
Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх
Хууль зүйн байнгын хорооны зөвлөх
Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалт, 33.11 дэх хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг.Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурлаас 2013 онд баталсан Цагдаагийн албаны тухай, Тахарын албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулиудын хэрэгжилт болон Шүүхийн шинэчлэлийн хүрээнд батлагдсан хуулиудын хэрэгжилттэй танилцах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ш.Түвдэндорж -Хууль зүйн байнгын хорооны дарга

Гишүүд:

Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн
О.Баасанхүү -Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Б.Чойжилсүрэн -Улсын Их Хурлын гишүүн

Хоёр.Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

С.Баярцогт -Улсын Их Хурлын гишүүн
Р.Бурмаа -Улсын Их Хурлын гишүүн
Д.Лүндээжанцан -Улсын Их Хурлын гишүүн

Гурав.Улсын ерөнхий прокурорын газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн
Б.Бат-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн

Дөрөв.Цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэг /хүсэлт, гомдол гаргах/, Арван тавдугаар бүлэг /эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл/-ийн заалтуудын хэрэгжилттэй танилцах болон хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

Ж.Батзандан	-Улсын Их Хурлын гишүүн
О.Баасанхүү	-Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар	-Улсын Их Хурлын гишүүн

Тав.Хил хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилттэй танилцах болон хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

О.Баасанхүү	-Улсын Их Хурлын гишүүн
Ш.Түвдэндорж	-Улсын Их Хурлын гишүүн
Б.Чойжилсүрэн	-Улсын Их Хурлын гишүүн

Зургаа.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилттэй танилцах, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлж төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад учирсан гэм хор, хохирлыг хэрхэн барагдуулж байгаатай танилцах болон хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

Д.Ганбат	-Улсын Их Хурлын гишүүн
Ц.Оюунбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
Б.Чойжилсүрэн	-Улсын Их Хурлын гишүүн

Долоо.Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилттэй танилцах болон хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

Ж.Батзандан	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Оюунхорол	-Улсын Их Хурлын гишүүн

Найм.Архивын ерөнхий газар, Оюуны өмчийн газрын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилттэй танилцах болон хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Гишүүд:

Д.Батцогт	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Оюунхорол	-Улсын Их Хурлын гишүүн
Ш.Түвдэндорж	-Улсын Их Хурлын гишүүн
Ө.Энхтүвшин	-Улсын Их Хурлын гишүүн


Ес.Дээрх ажлын хэсгүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх болон холбогдох бусад бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1.Ж.Баярцэцэг	-Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга
2.Э.Түвшинжаргал	-Хууль зүйн байнгын хорооны Ахлах зөвлөх
3.Ч.Батбямба	-Хууль зүйн байнгын хорооны референт
4.О.Алтангэрэл	-Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
5.Ж.Наранпүрэв	-Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
6.Б.Баярсайхан	-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа, удирдлагын газрын дарга
7.Б.Үнэнбат	-Улсын ерөнхий прокурорын туслах, Тамгын газрын дарга
8.Ж.Ганбаатар	-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа
9.Д.Батжаргал	-Нийслэлийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа
10.Ц.Мягмардорж	-Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга бөгөөд штабын дарга, хурандаа
11.Б.Амардорж	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Тогтоол гүйцэтгэх газрын дарга, хурандаа
12.Д.Дамдинцэрэн	-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа
13.Б.Пүрэвдорж	-Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга
14.И.Саруул	-Архивын ерөнхий газрын дарга

15.Н.Чинбат
16.Ц.Цэрэн
17.Б.Баярмаа

-Оюуны өмчийн газрын дарга
-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн зөвлөх
-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн референт.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ

БАТЛАВ:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ш. ТҮВДЭНДОРЖ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ТАНИЛЦАХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН
ХЭСГИЙН УДИРДАМЖ

2013 оны 10 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг.Танилцах, хяналт шалгалт хийх ажлын зорилго: Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 15 тоот тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газрын үйл ажиллагаатай танилцах мөн тус байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулж байгаатай танилцаж, хяналт шалгалт хийхэд ажлын зорилго оршино.

Хоёр.Ажлын хэсгийн ажиллах хугацаа: 2014 оны 01 дүгээр сарын 13-наас мөн оны 4 дүгээр сарын 05-ны хооронд явагдана.

Гурав.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн: Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын гишүүдээс гадна ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх болон холбогдох бусад бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий дэд ажлын хэсэг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байна.

- | | |
|------------------|--|
| 1.Ж.Баярцэцэг | -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга; |
| 2.Э.Түвшинжаргал | -Хууль зүйн байнгын хорооны Ахлах зөвлөх; |
| 3.Ч.Батбямба | -Хууль зүйн байнгын хорооны референт; |
| 4.О.Алтангэрэл | -Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; |
| 5.Ж.Наранпүрэв | -Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч; |
| 6.Б.Баярсайхан | -Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа, удирдлагын газрын дарга; |
| 7.Б.Үнэнбат | -Улсын ерөнхий прокурорын туслах, Тамгын газрын дарга; |
| 8.Ж.Ганбаатар | -Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа; |
| 9.Д.Батжаргал | -Нийслэлийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа; |
| 10.Ц.Мягмардорж | -Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга бөгөөд штабын дарга, хурандаа; |
| 11.Б.Амардорж | -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Тогтоол гүйцэтгэх газрын дарга, хурандаа; |
| 12.Д.Дамдинцэрэн | -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа; |

13.Б.Пүрэвдорж	-Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга;
14.И.Саруул	-Архивын ерөнхий газрын дарга;
15.Н.Чинбат	-Оюуны өмчийн газрын дарга;
16.Ц.Цэрэн	-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн зөвлөх;
17.Б.Баярмаа	-Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн референт.

Дөрөв.Ажлын хэсэг дараах байгууллагын үйл ажиллагаатай танилцана:

- 1.Хууль зүйн яам;
- 2.Улсын дээд шүүх;
- 3.Шүүхийн ерөнхий зөвлөл;
- 4.Улсын ерөнхий прокурорын газар.

Тав.Ажлын хэсэг дараах байгууллагуудаар явж танилцах болон хяналт, шалгалт хийнэ:

- 1.Цагдаагийн ерөнхий газар;
- 2.Нийслэл, дүүргийн цагдаагийн байгууллага;
- 3.Хил хамгаалах ерөнхий газар;
- 4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар;
- 5.Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба;
6. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар;
7. Архивын ерөнхий газар;
8. Оюуны өмчийн газар.

Зургаа.Гүйцэтгэх ажлууд:

1. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газрын үйл ажилаагаатай танилцах мөн Хууль зүйн яам, түүний харьяа агентлагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулан ажиллаж байгаатай танилцаж, хянаж шалгах;

2.“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн хэрэгжилттэй танилцах, хяналт шалгалт хийх;

3.Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэг /хүсэлт, гомдол гаргах/, Арван тавдугаар бүлэг /эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл/-ийн заалтуудын хэрэгжилттэй танилцах, хяналт, шалгалт хийх;

4.Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлж төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад учирсан гэм хор, хохирлыг хэрхэн барагдуулж байгаатай танилцах, хяналт, шалгалт хийх;

5.Иргэний хохирол барагдуулах шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа, төлбөр барагдуулалт, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хэрхэн ханган ажиллаж байгаатай танилцах, хяналт, шалгалт хийх;

6.Ажлын хэсгийн тайланг бэлтгэж Байнгын хорооны хуралдаанд мэдээлэл хийх.